



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/600

Хэрлэн сум

“Талын түмэн адуу 2025” эвент арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.9 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 3.2.8.1.2 –д тусгагдсаны дагуу жил бүр зохион байгуулагддаг “Талын түмэн адуу 2025” аялал жуулчлалын өвлийн эвент арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Аймгийн Засаг даргын орон тооны зөвлөх

Нарийн бичгийн
дарга:

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны намын бүлэг, төлөөлөгчдийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан

Байгаль орчны газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын дарга

Цагдаагийн газрын дарга

Онцгой байдлын газрын дарга

Хүнс хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтсийн дарга

Биеийн тамир, спортын газрын дарга

Аймгийн музейн захирал

2.

БЗӨБЦТС ТӨХК-ний Хэнтий цахилгаан түгээх сүлжээ
салбарын дарга

Хан Хэнтий чуулгын дарга

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч

Монгол тайга нохой судлалын холбооны тэргүүн
(зөвшилцсөнөөр)

Мөнх –Харилцаа ТББ-ын тэргүүн (зөвшилцсөнөөр)

Хэнтий аймгийн аялал жуулчлалын холбооны тэргүүн

Морьтон Монгол Залуус ТББ-ын тэргүүн

Гүртэн сээр ТББ-ын тэргүүн


Морьтон Монголжин Хэнтий аймаг дахь салбар хороо

2.Замын хөдөлгөөн, аюулгүй байдал, хэв журам сахиулах ажлыг цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа Д.Хатанбаатар)-д даалгасугай.

3.Эвент арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөрийг нарийвчлан гаргаж бэлтгэл ажлыг хангаж, өндөр түвшинд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Тайванжаргал)-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ДАЮУРБУНЬ

ਮੁਕਤ ਮਨੁ ਮਨੁ ਮਨੁ

